

Аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга нартай
2021 онд хамтран ажиллах гэрээний 4 дүгээр хавсралт

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Зорилт	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
				Он	Түвшин			
ЗОРИЛТ 1. ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН БОДЛОГО, ШИЙДВЭР БАТАЛЖ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭД ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧИЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛНА.								
1.1	Иргэд, олон нийтийн эрх ашгийг хөндсөн (Захиргааны хэм хэмжээ тогтоосон) шийдвэр боловсруулах, батлахдаа Захиргааны ерөнхий хуулинд нийцүүлэн, төслийн шатанд иргэдээ сонсох, саналыг нь авах, хэлэлцүүлэх зэргээр тэдний оролцоог хангах үйл ажиллагааг тогтмолжуулж, Хууль эрх зүйн хэлтсээс зөвлөгөө дэмжлэг авч, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлэн мөрдөх. (Захиргааны ерөнхий хуулийн 26, 27, 29, 59, 60, 61, 62, 64 дүгээр зүйл)		Баталсан захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг ХЗДХЯ-нд бүртгүүлж, мөрдсөн хувь	2020	100	Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр бүрийг ХЗДХЯ-нд бүрэн (100%) хянуулж, бүртгүүлэн мөрдөх үйл ажиллагаа хэвших.	Иргэд, олон нийтийн эрх ашгийг хөндсөн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гараагүй.	90
1.2	Сумын Засаг даргын захирамж, шийдвэрийг батлагдсан хуваарийн дагуу Хууль, эрх зүйн хэлтсээр хянуулж, зөвлөмжийг хэрэгжүүлэх. (МУЗЗНДНТУТ хууль 30.1.9)		Захирамж, шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хугацаанд нь хянуулсан хувь, -Зөрчил залруулсан хувь (аймгийн дүн)	2020	86.6% 60.6%	Захирамж, шийдвэрийн хууль зүйн үндэслэл бүрэн(100%) хянагдаж, алдааг залруулж, эрх зүйн зөрчилгүй шийдвэр хэрэгжих.	Засаг даргын А/Б захирамж 16, Тамгын газрын даргын А/Б тушаал 15, нийт 31 эрх зүйн актыг хянуулж зөвлөмжөөр илэрсэн зөрчлийг арилгаж хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажилласан.	90
1.3	“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, иргэд, олон нийтэд хууль зүйн нэгдсэн тусламж, үйлчилгээ, зөвлөгөө, мэдээллээр үйлчилж, албан ба албан бус эрх		-Эрх зүйн сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн хувь (аймгийн дүн)	2020	5%	Эрх зүйн сургалт, сурталчилгаа зөвлөгөө, мэдээллийг сумын иргэд, олон нийтийн 10-аас доошгүй	“Бүх нийтийн эрх зүйн боловсрол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Мөн энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗДТГ-ын даргаар ахлуулсан “Эрх зүйн хөтөч”	70

	зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулах.					хувьд хүргэсэн байх.	баг ажиллаж байна. Сумын эрх зүйн хөтөч багаас 2021 онд судлан сурталчлах хууль эрх зүйн актын төлөвлөгөөнд 60 хууль тогтоомжийг судлуулахаар төлөвлөсөн. Үүнээс танхимаар 28 хууль тогтоомжийг төрийн албан хаагчдад танилцуулж давхардсан тоогоор 208 иргэд, төрийн албан хаагч хамрагдсан. Эрх зүйн хөтчөөр сумын НТБ-ын багш Н.Оюунцэцэг, Г.Хандмаа, Б.Мөнхтамир нар бэлтгэгдсэн. Шинээр ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн, ЕБС-ийн түүх нийгмийн багш эрх зүйн хөтчөөр ажиллаж байна. 2021 он гарсаар коронавирусын халдвараас урьдчилан сэргийлж танхимын сургалт явагдахгүй байгаа учир шаардлагатай мэдээллийг цахимаар нийтэд түгээж 40 гаруй мэдээ мэдээллийг 434 иргэнд хүргэсэн байна.	
1.4	Сумдын “Эрх зүйн хөтөч” нарт дэмжлэг үзүүлж, удирдлага, арга зүйгээр хангаж, чадавхжуулах, нэгдсэн арга хэмжээнд хөтөлбөр, хуваарийн дагуу оролцуулж, багийн Засаг дарга, Насан туршийн боловсролын нэгж болон бусад албан тушаалтнуудтай хамтран баг бүрт үйл ажиллагаа зохион байгуулж, журмын дагуу ажиллуулах. (“Олон Улсын Хүний эрхийн өдөр”/2021.12.10/-ийг угтсан иргэдийн эрхийг хамгаалах хууль зүйн сургалт сурталчилгаа г.м)		-Эрх зүйн хөтөчүүдийг чадавхжуулсан арга хэмжээний тоо (нэгдсэн) -Хамтран зохион байгуулсан арга хэмжээний тоо,	2020	1	Эрх зүйн хөтөчүүдийг чадавхжуулж, хамтран олон нийтийг хамарсан 4-өөс доошгүй арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцсон байх.	АЗДТГ-аас 2021.05.11-ний өдөр сумдын эрх зүйн хөтөч нарт зохион байгуулсан албан бус сургалтанд 4 эрх зүйн хөтчийг хамруулж хөтчүүдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн. Эрх зүйн хөтөч багаас төрийн байгууллагын нийт 75 албан хаагчдад 3 удаагийн сургалтаар хууль эрх зүйн мэдээ мэдээллийг хүргэсэн. “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг цахим хэлбэрээр дээшлүүлэх нь” аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 13 заалттайгаар батлан хэрэгжилтийг зохион байгуулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Иргэд олон нийтэд цахим сүлжээгээр хууль эрх зүйн мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.	70

1.5	ХЗДХЯ, Авлигатай тэмцэх газар, Хууль, эрх зүйн хэлтсээс бэлтгэсэн тв шторк, CD, инфографик, кино, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулж иргэд, олон нийтэд хүргэх.		-байршуулсан, сурталчилсан мэдээллийн тоо,	2020	65	Хууль зүйн сурталчилгаа мэдээллийг иргэд, олон нийтэд цахим хэлбэрээр 25-аас доошгүй удаа, лед дэлгэц, самбараар 10 доошгүй удаа тус тус хүргэсэн байх.	ХЗДХЯ, Авлигатай тэмцэх газар, Хууль, эрх зүйн хэлтсээс бэлтгэсэн тв шторк, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, гарын авлагыг сумын фэйсбүүкийн цахим хуудсаар дамжуулан мөн сурталчилгааны самбарт байршуулж иргэд, олон нийтэд хүргэж байна.	50
ЗОРИЛТ 2. ТӨРИЙН АЛБАНД ШУДАРГА ЁС, ИЛ ТОД БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЖ, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛНЭ.								
2.1	Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, хэрэгжилт үр дүнг хурал, зөвлөл(ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын Зөвлөл)-өөр хэлэлцүүлэн үнэлүүлж эрчимжүүлэх, тайлагнах.		-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь (сумын дүн) -Тайлан ирүүлсэн хугацаа	2020	80%	Төлөвлөгөөг 80-аас дээш хувиар хэрэгжүүлэн, үнэлүүлж, хугацаанд нь тайлагнах.	Цагаандэлгэр сумын ЗДТГ-ын 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2021.02.22-ны өдөр сумын Засаг даргаар батлуулан байгууллага, албан хаагчдад хүргүүлж танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	50
2.2	Авлигатай тэмцэх газраас санаачилсан авлигын эсрэг аян, сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг нутаг дэвсгэрийн онцлог, өөрсдийн нөөц бололцоонд тохируулан иргэд, хүүхэд залуусыг хамруулан зохион байгуулж, авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах.		-Самбартай болж, ажиллуулсан эсэх(сум бүр) -Зохион байгуулсан арга хэмжээний тоо -Арга хэмжээнд хамрагдсан хүүхэд залуус, иргэдийн тоо (аймгийн дүн)	2020	1 1 3600	Сум бүр “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулж, 2-оос доошгүй нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулж, 250-аас доошгүй иргэн, хүүхэд хамруулах,	Байгууллагын 11 албан хаагчдад гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаар танилцуулж цахим хуудсаар дамжуулан авилгаас урьдчилан сэргийлэх мэдээллийг 3 удаа байршуулж, иргэд олон нийтэд мэдээллийг хүргүүлсэн. Нийтийн албан тушаалтын Хамаарал бүхий этгээдийн судалгааг гарган цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж мэдээлсэн. Авлигаас урьдчилан сэргийлэх сэдэвт гарын авлага боловсруулан мэдээллийн самбарт байршуулан 65 иргэнд сурталчилгааны материал тараасан.	50
2.3	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянуулж,		-ХАСУМ-ийг хянуулсны дараа томилогдсон	2020	-	Ашиг сонирхлын зөрчлийг 100% хянуулж томилогдох,	2021 оны 4-р сард ЗДТГ-ын санхүү албаны даргаар томилогдох Б.Цэндмаа, 5-р сард ЕБС-ийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч	90

	томилогдсон албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулах.		албан тушаалтны эзлэх хувь, -ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь мэдүүлсэн хувь		100%	ХАСХОМ-ийг 100% хугацаандаа мэдүүлэх.	Д.Октябрь, 6-р сард ЭМТ-ийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч Н.Мөнхбаяр нарын нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хүргүүлэн хянуулсан ба 1 албан хаагчийг томилогдсоноос хойш 30 хоногт багтаан ХАСХОМ-ыг гаргуулж цахимд бүртгэн баталгааны маягтаар баталгаажуулсан.	
2.4	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл гаргаж, ЭБАТ цэсний бүртгэлүүдийг бүрэн хөтөлж, дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох.		Мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргасан ил тод сурталчилсан хувь	2020	-	Мэдэгдэл, тайлбарыг олон нийтэд бүрэн ил тод сурталчилсан байх	Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх 1 мэдэгдэл тайлбарыг хүлээн авч бүртгэн цахимд мэдээлсэн. Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбар гаргасан албан хаагч байхгүй.	90
ЗОРИЛТ 3. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ЧИГЛЭСЭН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛНЭ.								
3.1	Сумын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл болон гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн хэсэг, хэсгийн төлөөлөгчийн зохиож буй үйл ажиллагааны талаар болон тулгамдаж буй асуудлаар сонсгол, мэдээллийг сумын Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, зохих шийдвэр гаргаж хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх, албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд үүрэг даалгавар өгч биелэлт үр дүнг тооцох.		-Тухайн суманд бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт өмнөх оноос буурсан хувь, (сумын дүн) -Цагдаагийн хэсэг, хэсгийн төлөөлөгчийн сонсгол, мэдээллийг хэлэлцүүлсэн тоо, үр дүн	2020	7.1%	Тухайн суманд бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт өмнөх оноос 3.1-ээс доошгүй хувиар буурах.	Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоон, гэмт хэрэг зөрчлөөс, урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж байна. Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр малчдын бүлгийг идэвхижүүлэн ажиллаж байна. Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар сонсгол, мэдээлэл зохион байгуулаагүй. Сумын төвд үйл ажиллагаа явуулдаг албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулгын гадна болон дотор хяналтын камерыг суурилуулах, цонх хаалгыг решотик төмөр хаалт хийх, COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр халдвар хамгааллын	70

							дэглэм сахиж ажиллах зэрэг үүрэг даалгавар өгч биелэлт үр дүнг тухай бүр тооцон ажиллаж байна	
3.2	Суманд ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг орон байр, тээвэр, холбооны хэрэгсэл, согтуурал хэмжих багажаар хангах, шаардлагатай урсгал зардал(халаалт, цахилгаан, засвар үйлчилгээ, шатахуун гэх мэт Адаацаг, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өндөршил сумд Цагдаагийн кабоныг засварлах, тохижуулах)-ыг шийдвэрлэж, гэр бүлийн гишүүнийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх. (Цагдаагийн албаны тухай хууль 94 дүгээр зүйл)		-Сум тус бүрийн зарцуулсан хөрөнгө оруулалт, зардал, Адаацаг, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өндөршил сумд Цагдаагийн кабоныг засварын гүйцэтгэл(хувь) -Тухайн суманд үйлдэгдсэн гэмт хэргийн илрүүлэлт өссөн хувь (аймгийн дүн)	2020	- 3.1%	Цагдаагийн алба хаагчийн ажиллах нөхцөл бүрэн хангагдаж, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд ахиц гарч, гэмт хэргийн илрүүлэлтийн хувь өсөх.	Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ажиллаж амьдрах орон байраар бүрэн хангагдсан. Цагдаагийн хэсгийг авто тээврийн хэрэгслээр ханган ажиллаж байгаа. Мөн цагдаагийн хэсгийг байнгын интернэттэй байлгаж интернетийн төлбөрийг төлж байна. Согтуурал хэмжих драгер багажаар хангагдсан. Эргүүл хяналт шалгалт болон дуудлага мэдээлэлд явах шатахуунаар бүрэн хангадан ажиллаж байна. Цагдаагийн кабоныг засварлах, тохижуулах хөрөнгө санхүү шийдэгдээгүй байна.	70
3.3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэг, осол зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхэд, иргэдийг хамгаалах, тусламж, зөвлөгөө, мэдээллээр үйлчлэх, сургалт, судалгааг шинэчлэх ажлыг холбогдох төрийн болон ТББ, албан тушаалтнуудтай хамтран эрчимтэй зохион байгуулах, хяналт, оролцоог тогтмолжуулах.		-Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт урд оноос буурсан тоо, (аймгийн дүн) -Зохион байгуулсан арга хэмжээний тоо, үр дүн	2020	1	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт өмнөх оноос буурах,	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн дагуу ахуйн хүрээний архидаг согтууралтыг сумын хэмжээнд багасгах зорилго тавин ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэлд өртөн хараа хяналтгүй байгаа сургуулийн насны хүүхдийг ЕБС-ийн сургууль, сумын Засаг даргын дэргэдэх хүүхэд хамгааллын хамтарсан багийн хурлаар хэлэлцэн, тухайн иргэдэд санамж өгч ажилласан. Сумын хэмжээнд ахуйн хүрээнд архидаг согтуурч, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг бага насны хүүхдийг хараа хяналтгүй байлгаж эрсдэлд нөхцөлд оруулдаг айл өрхийн судалгааг цагдаагийн хэсгээс судлан гаргаж хяналт тавьж ажиллаж байна. Энэ онд гэр бүл хүчирхийллийн зөрчил гаргасан 1 иргэн хуульд заагдсан арга хэмжээг тооцон хяналт судалгаанд аван ажиллаж байна.	70

3.4	Архидан согтуурахтай тэмцэх аймгийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд идэвх, санаачлагатай оролцож, холбогдох байгууллага, иргэдэд дэмжлэг үзүүлж, урьдчилан сэргийлэх үр дүнтэй ажил, арга хэмжээг орон нутгийн иргэдийг өргөнөөр хамруулан зохион байгуулах,		-Тухайн суманд бүртгэгдсэн согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт өмнөх оноос буурсан хувь (аймгийн дүн)	2019 2020	22.2% (өссөн) Ижил	Тухайн суманд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг(зөрчил)-ийн гаралт өмнөх оноос буурах	Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр сумын Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 албан тоотын хэрэгжилтийг хангаж сар бүрийн 5,15,25-ны өдрүүдэд архи согтууруулах ундааг худалдан борлуулахгүй байхад хяналт тавьж сумын шуурхай штаб, цагдаагийн хэсгээс ажлын хэсэг гарган тоолж лацдаж ажилладаг. Мөн ИТХурал, ЗДТГ-аас архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг Угтаал трейд ХХК, Сайн-Гашуун ХХК-ны архи согтууруулах ундааны нэр төрөл болон, үнийн судалгааг авч хяналт тавьж ажилласан. Аймгийн прокурорын газрын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 06 тоот албан мэдэгдлийн дагуу ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлж хөл хорионы дэглэмийн үед иргэд согтуугаар тээврийн хэрэгсэл барьж хөдөлгөөнд оролцсон зөрчлийг арилгах мэдэгдлийн дагуу сумын эрүүл мэндийн төв, цагдаагийн хэсгийн төлөөлөгч нартай хамтран иргэдэд архины хор хөнөөл, замын хөдөлгөөний аюулгүй байдал, зөрчлийн тухай хууль тогтоомжоор сургалт хийсэн.	90
3.5	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, багийн Засаг дарга нар болон малчид иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах, идэвх оролцоо, хариуцлага, сонор сэрэмжийг сайжруулах ажил, арга хэмжээг үе шаттай зохион байгуулах.		-Мал хулгайлах гэмт хэргийн гаралт урд оноос буурсан хувь (аймгийн дүн) -Зохион байгуулсан арга хэмжээний тоо, үр дүн	2019 2020	38.1% өссөн 37.9% -	Мал хулгайлах гэмт хэргийн гаралт урд оноос 0.2-оос багагүй хувь буурах, Нийтийг хамарсан 4-өөс доошгүй арга хэмжээ зохион байгуулах,.	Сумын нутаг дэвсгэрт отор нүүдэл их байсны улмаас малын хулгайн гэмт хэргийн дуудлага, иргэдийн гомдол их байна. Үүний дагуу багийн Засаг дарга нар отроор яваа малчин өрхийн нэгдсэн судалгааг гаргаж, малчид ард иргэдэд малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цахимаар болон иргэдэд утсаар нэг бүрчлэн ярьж сонор сэрэмжтэй байх	70

							талаар тогтмол мэдээлэл өгч ажиллаж байна.	
3.6	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтад заасны дагуу харьяа нутаг дэвсгэртээ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр бодитой ажил, арга хэмжээ зохион байгуулах, шаардлагатай хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.		-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын эсрэг гэмт хэргийн гаралтын урд оноос буурсан тоо	2020	1	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын эсрэг гэмт хэргийн гаралт урд оноос буурах.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр эргүүл хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж, орон нутгийн замын хөдөлгөөнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгах, гаргасан зөрчилд арга хэмжээг тооцон ажилласан. Энэ онд отор нүүдэл их байгаатай холбоотой тээврийн хэрэгсэл, иргэдийн хөдөлгөөн их байна. Зам тээврийн осол гэмтлээс урьчилан сэргийлэх чиглэлээр бүрэн бус тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байхад анхаарч авто тээврийн хэрэгслийг үзлэг оншилгоонд бүрэн хамруулан ажилласан.	90
3.7	Албан байгууллага, аж ахуйн нэгжийн идэвх, санаачлагыг өрнүүлж, нийтийн эзэмшлийн орон сууц, үйлчилгээний байгууллага, аж ахуй нэгжийн гадна орчин, машины зогсоол, гэр хорооллын гудамж, талбайд дэвшилтэт технологи бүхий камержуулалт, гэрэлтүүлэг нэвтрүүлэх, шинэчилж нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, гэмт хэргээс, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх. (Мандалговь хот камерын ашиглалтыг судлах, шинэчлэх)		-Гудамж тайлбайд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтын урд оноос буурсан хувь, (аймгийн дундаж) -Шинээр нэвтрүүлсэн, шинэчилж засварласан камер, гэрэлтүүлэгийн тоо,	2020	-75% (өссөн)	Шинэ камер, гэрэлтүүлэг нэмэгдэж, гудамж тайлбайд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтын урд оноос буурах.	2021 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар сумын төвд нэгдсэн суурилуулах ажлыг ИТХурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүний дагуу “Мастер бригад” ХХК-тай гэрээ байгуулж 2021.06.20-нд хүлээн авахаар ажиллаж байна. Албан байгууллага, аж ахуй нэгжүүд гадна талдаа авто машины нэгдсэн зогсоолыг хийж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. Сумын төвийн гэрэлтүүлэг бүрэн хэмжээнд ажиллаж байна. Цаашид сургуулийн дотуур байрны камерын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.	70
ЗОРИЛТ 4. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ ТОГТООМЖ, СТАНДАРТЫГ БҮРЭН МӨРДҮҮЛЖ, УДИРДЛАГЫН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛЖ, АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТНУУДЫГ МЭРГЭШҮҮЛНЭ.								
4.1	Байгууллагын зохион байгуулалтын нэгж, ажилтнууд “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ын дагуу баримтыг эмхлэн цэгцэлж.		-Баримтаа байгууллагын архивт шилжүүлсэн хувь	2020	80	Алба хаагч нар баримтаа 100 хувь бүрэн шилжүүлэх	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан байгууллага, албан хаагч нар графикийн дагуу нийт 135	90

	байгууллагын архивт хуваарийн дагуу шилжүүлэх.						баримтыг байгууллагын архивт 100% шилжүүлсэн байна.	
4.2	Байнга, түр хадгалах баримтын данс, бүртгэл, устгах хэргийн актыг байгууллагын БНШК болон Төрийн архивын БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлж, баталгаажуулах.		-Бүртгэлүүдээ батлуулсан эсэх	2020	1	Холбогдох заавар, журмын дагуу Төрийн архиваар бүртгэлүүдээ батлуулах.	Байнга хадгалах баримт, түр хадгалах баримт данс, бүртгэл, устгах хэргийн актыг байгууллагын БНШК болон Төрийн архивын БНШАЗК-ын хурлаар 2012-2019 он хүртэл хэлэлцүүлж, баталгаажуулсан байна.	90
4.3	Сумдын ЗДТГ-ын архивыг зориулалтын нягтруулсан шүүгээ болон орчин үеийн шаардлагад нийцсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх,		-Архивт хийсэн засвар үйлчилгээ, нягтруулсан шүүгээ болон бусад тоног төхөөрөмжийн хангалт	2020	-	Архивын баримт бичгийн хадгалалт хамгаалалт сайжирсан байх.	ЗДТГ-ын архивын өрөөг тохижуулж 2ш төмөр тавиурыг 1900000 аваад байна. Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаад байна.	90
4.4	Архивын Ерөнхий газраас 2021 онд зохион байгуулах сургалтанд сум, байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудыг захиалгын дагуу суралцуулах,		-Сургалтанд хамрагдсан алба хаагчдын хувь	2020		Архив, бичиг хэргийн ажилтнуудыг хуваарийн дагуу сургалтанд 100% хамруулах.	Архивын Ерөнхий газраас 2021 онд зохион байгуулах сургалтанд 8 сард захиалга өгөөд байна.	50
4.5	Адаацаг, Дэрэн, Дэлгэрцогт, Луус, Хулд, Гурвансайхан, Дэлгэрхангай, Цагаандэлгэр сумдын Улсын бүртгэгчдэд бүртгэлийн анхан шатны нотлох баримтыг цахимжуулахад шаардлагатай 3 үйлдэлт принтерээр хангахад дэмжлэг үзүүлэх.		-Сум тус бүрийн зарцуулсан хөрөнгө оруулалт, зардал	2020	-	Бүртгэлийн үйл ажиллагаанд шаардлагатай төхөөрөмжөөр хангагдсан байх.	Коронавируст халдварын нөхцөл байдлын улмаас төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнээр тоног төхөөрөмж авах зардал 12 сар хүртэл татагдсан.	30
ЗОРИЛТ 5. ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭНИЙ ТАЙЛАН, МЭДЭЭГ ЧАНАРТАЙ ГАРГАЖ, ХУГАЦААНД НЬ ХҮРГҮҮЛНЭ.								
5.1	Хууль зүйн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээг Хууль зүйн сайдын 2017.07.10-ны А/182 дугаар тушаалаар батлагдсан ажлын үр дүнг үнэлж, дүгнэх журмын дагуу тайлагнана.		-Тайлан, мэдээг хугацаанд ирүүлсэн эсэх	2020	2	Үр дүнг үнэлж хугацаанд нь тайлагнасан байх	2019 онд хууль эрх зүйн хүрээнд хийгдсэн ажлын тайлан мэдээг А/182 дугаар тушаалаар баталсан журмын дагуу гаргаж тайлагнасан.	50
5.2	Бүх нийтийн эрх зүйн боловсролын үндэсний зөвлөлөөс батлагдсан журам, гэрээний дагуу “Эрх зүйн		-Эрх хөтөчийн ажлыг шалгуур	2020	2	Эрх зүйн хөтөчийн ажлыг дүгнэсэх байх	Эрх зүйн хөтчөөр сумын НТБ-ын багш Н.Оюунцэцэг, Б.Мөнхтамир нар бэлтгэгдсэн. Шинээр ЗДТГ-ын	50

	хөтөч"-ийн ажлыг шалгуур үзүүлэлтээр дүгнэж, нэгдсэн тайлан, мэдээг ирүүлнэ.		үзүүлэлтээр дүгнэсэн эсэх				нийгмийн бодлогын мэргэжилтэн, ЕБС-ийн түүх нийгмийн багш эрх зүйн хөтчөөр ажиллах гэрээ байгуулсан. Бүх нийтийн эрх зүйн боловсролын үндэсний зөвлөлөөс батлагдсан журмын ажлын тайланг ажлыг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж байна.	
5.3	Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнана.		-Ашиг сонирхлын зөрчлийн тоо	2020	2	Зөвлөмжөөр өгөгдсөн үүрэг хангагдсан байх	Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.	50
5.4	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн ХАСХОМ-1 тайлан(ХАС хураангуй, ХОМ хураангуй тайлан)-г үнэн зөв гаргаж хугацаанд нь тайлагнана.		-Тайлан мэдээг зөв гаргасан эсэх	2020	1	Тайлан мэдээг үнэн зөв гаргаж тайлагнасан байх	ХАСХОМ гаргах 5 албан тушаалтын ХОМ-ыг хуулийн хугацаанд авч Авлигатай тэмцэх газрын даргын 2012.06.13-ны өдрийн 91 дүгээр тушаалын 1, 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан ХАСХОМ-1, ХАСХОМ-2, ХАСХОМ-3, ХАСХОМ-4, ХАС хураангуй тайланг хянаж шалган хугацаанд нь аймгийн ЭБАТ-д хүргүүлсэн.	90
5.5	Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг дүгнэх хуудас, хурал, зөвлөлөөр үнэлүүлсэн шийдвэрийн хамт тайлагнана.		-Дүгнэх хуудасны тоон үзүүлэлт, хамруулсан тоо -Шийдвэрийн тоо	2020	2	Сумын ИТХ болон Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж үнэлүүлсэн байх	Сумын 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2021.02.22-ны өдөр сумын Засаг даргаар батлуулан байгууллага, албан хаагчдад хүргүүлж танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг ирүүлэх дүгнэх хуудсыг төлөвлөгөөний хамтаар төрийн байгууллагын удирдлагуудад хүргүүлсэн.	50
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ								70

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР